



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 01 дугаар сарын 25

№ 01/01 ДУА-2018/17/СТА-ТЧЗ

Мандалговь хот

**Г Зөрчил арилгуулах тухай Т**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Соёлын төвийн 2017 оны 4 дугаар улирлын санхүүгийн тайланд санхүүгийн аudit хийх явцад нийт 562,000.00 төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Бэлэн мөнгөний шилжүүлэг хийхдээ хязгаар хэтрүүлэн гаргасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ гаргасан. /Мөнгөн кассын ажиллагааны журмын 5.3-т "Төсвийн байгууллага нь төлбөрийн картаар дамжуулан авсан жижиг мөнгөн сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг төлбөрийн картын дансны дэлгэрэнүй хуулгын хамт хянуулан дараагийн ЖМС авах эрхээ энэгээс", 6.3-т Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дун нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна."заасан заалтуудыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д/Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага огөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөх/ Төрийн аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Соёлын төвийн эрхлэгч Ж.Эрдэнэцэцэг, нягтлан бодогч О.Уранбилэг нарт хариуцуулав.

1. Бэлэн мөнгөний дээд хязгаар хэтрүүлэн гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Соёлын төвийн эрхлэгч Ж.Эрдэнэцэцэг, нягтлан бодогч О.Уранбилэг нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**  
АУДИТОР Ж.УГТАХБАЯР

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ЭРХЛЭГЧ Ж.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
НЯГТЛАН БОДОГЧ О.УРАНБИЛЭГ

1481714423  
3KTA-005  
Албан шаардлагыг биелэхт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/